

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ОМА-2024/18-15-ШТА-ГА

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙГ ХУУЛЬД
НИЙЦҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Даланзадгад хот 2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Шижирболд
Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn
Аудитор Э.Бат-Эрдэнэ
Утас: 70533552 Цахим хаяг: baterdennee@audit.gov.mn
Аудитор Г.Амарзаяа
Утас: 70533552 Цахим хаяг: Amarzaya@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар
авна уу: Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлал.....	2
Хүснэгтийн жагсаалт.....	2
Дүрслэлийн жагсаалт.....	2
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх.....	3
БҮЛЭГ 1. ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА	5
A.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд зөрчил давтан гарсаар байна.....	5
A.2 Зарим төсөл, арга хэмжээнд нэмэлт гэрээ байгуулж төсөвт өртгийг нэмэгдүүлсэн байна	7
A.3 Зарим төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна	8
БҮЛЭГ 2. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА	10
B.1 Худалдан авах ажиллагааг төлөвлөгөөт хугацааны дагуу хэрэгжүүлэхгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна	10
B.2 Зарим төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу шалгаруулаагүй байна	11
БҮЛЭГ 3. ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛД ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮНГ БУУРУУЛЖ БАЙНА	13
B.1 Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд илэрсэн зөрчил хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна	13
B.2 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.....	16
B.3 Шинээр бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байх зөрчил буурсан байна.....	17
БҮЛЭГ 4. ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ БАЙГАА НЬ ҮР ДҮНГ БУУРУУЛЖ БАЙНА	18
Г.1 Зарим төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу ашиглахгүй байна	18
Г.2 Зарим төсөл, арга хэмжээ нь хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шаардлага хангаагүй байгаа нь үр дүнг бууруулж байна	19
ДҮГНЭЛТ.....	21
ЗӨВЛӨМЖ.....	22
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	23

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ШТА	Шууд тайлагнах аудит
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ЗҮГСЖ	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	<i>Баталсан төсөл, арга хэмжээ</i>	5
Хүснэгт 2	<i>2023 оны шинэ, шилжих ТАХ-ны судалгаа</i>	7
Хүснэгт 3	<i>Төсөл, арга хэмжээний ангилал</i>	9
Хүснэгт 4	<i>ТАХ-ы гүйцэтгэл, ХАА-нд мөрдөгдсөн журам</i>	11
Хүснэгт 5	<i>ТАХ-ыг задалсан байдал /Жишээ нь/</i>	12
Дүрслэл 1	<i>ХАА-ны төлөвлөгөө, гүйцэтгэл</i>	10
Дүрслэл 2	<i>ТАХ-ы гүйцэтгэл өмнөх онтой харьцуулсан байдал</i>	12

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/162 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилго

Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэсэн. Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх?
- Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх?
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх?
- Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх?

Аудитын хамарсан хүрээ

Аудитад түүврийн арга ашиглан Өмнөговь аймагт 2023 онд орон төсвийн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол улсын аудитын стандарт MNS 6817-5:2020, гүйцэтгэлийн аудитын зарчим MNS 6817-6:2020, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад асуудлын шинжилгээний дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт,
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн албаны тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- “Алсын хараа” 2050 Монгол Улсын урт хугацааны урт хугацааны хөгжлийн бодлого,

- Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”,
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,
- Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Хонгорзул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Шижирболд, аудитор Э.Бат-Эрдэнэ, Г.Амарзаяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Хүндрэл бэрхшээл:

Өмнөх онд аймаг, сумдын орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 439 төсөл, арга хэмжээнд 122,352.9 сая төгрөг, 2023 онд 770 төсөл, арга хэмжээнд 363,503.8 сая төгрөг батлагдсан байна. Энэ нь өмнөх оноос даруй 241,150.9 сая төгрөгийн 331 төсөл, арга хэмжээгээр нэмэгдсэн байна. Орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагын хүн хүчний нөөц хязгаарлагдмал, нарийн мэргэжлийн боловсон хүчин хангалтгүй байгаа нь хөрөнгө оруулалтыг бүрэн хэмжээгээр шалгах боломжгүйд хүргэж, аудитын үр дүнг бууруулж байна.

БҮЛЭГ 1. ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

А.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд зөрчил давтан гарсаар байна.

1.1 Аймгийн ИТХ-ын 2022 оны 12-р сарын 01-ний өдрийн 9/15 дугаар тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хийх 162 төсөл, арга хэмжээнд 194,925.2 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

1.2 Төсөвт тодотгол хийж 2023 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн 13/11 дугаар тогтоолоор ерөнхий нэрээр 235 төсөл, арга хэмжээнд нэр төрлөөр задалбал 456 төсөл, арга хэмжээнд 273,289.7 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

1.3 Мөн 10 сумд ИТХ тогтоолоор 2023 онд нийт 314 төсөл, арга хэмжээнд 90,214.1 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

Хүснэгт 1 2023 оны батлагдсан төсөв, ОНТХО-ын төлөвлөгөө

№	Сумд	Нийт орлого	Нийт зарлага	ОНТХО-ын	
				ТАХ-ий тоо	Дүн /сая.төгрөг/
1	Баяндалай	2,614.2	2,614.2	1	10.0
2	Баян-Овоо	3,921.6	3,921.6	11	775.0
3	Булган	2,262.4	2,262.4	-	-
4	Гурвантэс	28,779.2	28,779.2	44	5,072.7
5	Даланзадгад	26,636.9	26,636.9	54	4,521.8
6	Мандал-Овоо	2,011.9	2,011.9	-	-
7	Манлай	3,812.8	3,812.8	9	396.0
8	Номгон	2,703.5	2,703.5	17	182.3
9	Ноён	3,353.50	3,353.50	-	-
10	Сэврэй	2,744.2	2,744.2	7	107.3
11	Ханбогд	237,425.1	237,425.1	112	73,417.1
12	Ханхонгор	2,269.2	2,269.2	6	163.9
13	Хүрмэн	2,130.6	2,130.6	-	-
14	Цогт-Овоо	2,384.9	2,384.9	-	-
15	Цогтцэций	62,386.3	62,386.3	53	5,568.0
16	Аймаг	940,800.9	940,800.9	456	273,289.7
	Нийт	1,326,137.2	1,326,237.2	770	363,503.8

Эх сурвалж: ИТХ-ын тогтоолууд

1.4 Аймгийн эдийн засаг өсөхийн хэрээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт ихээр нэмэгдэж байгаа сумд байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4,000.0 сая төгрөгөөс дээш төсөв баталсан 4 сум байна. Тухайлбал Ханбогд сумын ИТХ-аар 73,417.1 сая төгрөг, Цогтцэций сумын ИТХ-аар 5,568.0 сая төгрөг, Гурвантэс сумын ИТХ-аар 5,072.7 сая төгрөг, Даланзадгад сумын ИТХ-аар 4,521.8 сая төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт тус тус баталжээ.

1.5 Сумдын ИТХ-р баталсан тогтоолууд нь харилцан адилгүй маягтаар бэлтгэсэн байна. Тухайлбал зарим тогтоол нь шинэ, шилжих төсөл, арга хэмжээг ангилагдаагүй төсөвт өртөггүй, эхлэх, дуусах хугацаагүй, эдийн засгийн ангилалгүй байна.

1.6 Төсвийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1-т орон нутгийн төсвийг батлахдаа тус хуулийн 33.2.6-д заасныг тусгаж батлахаар заажээ. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалтын

төсөл, арга хэмжээний жагсаалтад нэр, байршил хүчин чадал, төслийн код, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүнг зааж, хавсралтаар батлахаар тусгасан. Хуулийн энэ заалтыг сум тус бүр харилцан адилгүй хэрэгжүүлж, төсөл, арга хэмжээний мэдээллийг дутуу тусгаж баталдаг байна.

1.7 Төсөл, арга хэмжээний мэдээллийг дутуу баталснаар иргэд, олон нийт бодитой, үнэн зөв мэдээллээр хангагдахгүй байх эрсдэлийг дагуулж байна. Иймд төсвийн тухай хуулийн 33.2.6-д заасан төсөл, арга хэмжээний мэдээллийг тусгаж байх албан шаардлагыг сумдын Засаг дарга нарт хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

1.8 УИХ-ын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагад шинээр олон нийтээр хэлэлцүүлсэн байх заалт нэмэгдсэн боловч хууль батлагдсанаас хойш төсөв тодотгосон тогтоолуудад хэрэгжүүлээгүй байна.

1.9 Энэ нь холбогдох албан тушаалтнуудын мэдлэг, хариуцлага сул байгаагаас шалтгаалсан байна. Иймд аймаг, сумдын Засаг дарга нарт зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

1.10 Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24¹-д заасантай нийцэхгүй орон нутгийн өмчлөлд хамаарахгүй, улсын төсвийн байгууллагуудын урсгал болон хөрөнгө худалдан авахад аймаг, сумд нийт 48 төсөл, арга хэмжээнд 4,553.8 сая төгрөг баталсан зөрчил илэрсэн. (Дэлгэрэнгүйг хавсралт №1) Үүнд:

- Аймаг 25 төсөл, арга хэмжээнд 3,204.0 сая төгрөг,
- Баян-Овоо сум 2 төсөл, арга хэмжээнд 196.9 сая төгрөг,
- Даланзадгад сум 4 төсөл, арга хэмжээнд 303.6 сая төгрөг,
- Цогтцэций сум 3 төсөл, арга хэмжээнд 335.7 сая төгрөг,
- Ханбогд сум 13 төсөл, арга хэмжээнд 444.1 сая төгрөг,
- Номгон сум 1 төсөл, арга хэмжээнд 69.5 сая төгрөг тус тус баталсан байна.

1.11 Энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалт бага төлөвлөгдөж байгаа, мөн аймгийн Засаг дарга Засгийн газрын сайдуудтай байгуулсан гэрээнд тусгадаг зэргээс шалтгаалдаг байна. Харин сумдын хувьд хуулийн мэдлэг хангалтгүй байгаатай холбоотой байна. Иймд аймаг, сумдын Засаг дарга нарт зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлээ.

1.12 Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-ын заалттай нийцэхгүй орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар зардлын шинж чанартай 3,913.0 сая төгрөгийн 52 төсөл, арга хэмжээг аймаг, сумд баталсан байна. (Дэлгэрэнгүйг хавсралт №2) Үүнд:

- Аймаг 26 төсөл, арга хэмжээнд 1,990.0 сая төгрөг,
- Сэврэй сум 1 төсөл, арга хэмжээнд 7.0 сая төгрөг,
- Манлай сум 2 төсөл арга хэмжээнд 59.0 сая төгрөг,
- Ханхонгор сум 1 төсөл, арга хэмжээнд 30.0 сая төгрөг,
- Баян-Овоо сум 1 төсөл, арга хэмжээнд 22.9 сая төгрөг,

¹ "Төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг

- Номгон сум 14 төсөл, арга хэмжээнд 138.0 сая төгрөг,
- Ханбогд сум 1 төсөл, арга хэмжээнд 1,000.0 сая төгрөг,
- Даланзадгад сум 5 төсөл, арга хэмжээнд 658.2 сая төгрөг,
- Гурвантэс сум 1 төсөл, арга хэмжээнд 7.9 сая төгрөг тус тус баталсан байна.

1.13 Дээрх зөрчилд аймаг, сумдын Засаг дарга нарт зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлээ.

1.14 Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4²-т заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвийг батлуулсан байх шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээ батлагдсанаас хойш боловсруулдаг нийтлэг зөрчил гарсаар байна. (Дэлгэрэнгүйг нэгдсэн судалгаанаас)

1.15 Дээрх зөрчлүүд жил бүрийн аудитаар давтагдан гарч байгаа нь төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг алдагдуулж, төсвийн төлөвлөлтийн зарчим хангагдахгүй байгааг харуулж байна.

1.16 Цаашид төсөв боловсруулж батлахдаа Төрийн аудитын байгууллагаас төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах саналыг авч байх шаардлагатай байна. Дээрх зөрчлүүдийн талаар Төрийн аудитын байгууллагаас өгсөн санал, дүгнэлтэд дурдагдсан байна.

А.2 Зарим төсөл, арга хэмжээнд нэмэлт гэрээ байгуулж төсөвт өртгийг нэмэгдүүлсэн байна.

1.17 Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор нийт 770 төсөл арга хэмжээнд 363,503.8 сая төгрөгийг баталснаас шинээр хэрэгжүүлэх 650 төсөл арга хэмжээнд 263,972.6 сая төгрөг, өмнөх оноос шилжсэн 120 төсөл, арга хэмжээнд 99,531.2 сая төгрөг тус тус баталсан байна. (Дэлгэрэнгүйг нэгдсэн судалгаанаас)

Хүснэгт 2 2023 оны шинэ, шилжих ТАХ-ны судалгаа

№	Аймаг, сумдын нэр	2023 онд шилжих ТАХ		2023 онд шинээр хийх ТАХ	
		ТАХ-ний тоо	Санхүүжүүлэх дүн /Сая төгрөг/	ТАХ-ний тоо	Санхүүжүүлэх дүн /Сая төгрөг/
1	Аймаг	81	93,769.2	375	179,520.5
2	Баяндалай	-	-	1	10.0
3	Баян-Овоо	-	-	11	775.0
4	Гурвантэс	6	403.5	38	4,669.2
5	Даланзадгад	11	957.1	43	3,564.7
6	Манлай	-	-	9	396.0
7	Номгон	-	-	17	182.3
8	Сэврэй	-	-	7	107.3
9	Ханбогд	10	2,732.3	102	70,684.7
10	Ханхонгор	-	-	6	163.9
11	Цогтцэций	12	1,669.1	41	3,899.0
	Дүн	120	99,531.2	650	263,972.6

Эх сурвалж: ИТХ-ын тогтоолууд

1.19 Өмнөх онд дуусаагүй төсөл, арга хэмжээнүүдийг тухайн онд санхүүжүүлэхээр тусгасан байна.

² Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

1.20 УИХ-ын 2021 оны 88 дугаар тогтоол, Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны 75 дугаар тушаалд хамаарахгүй 11 төсөл арга хэмжээнд 1,808.8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг аймгийн орон нутгийн төсвөөс олгосон байна. Энэ нь нийт төсөл арга хэмжээний 1.4 хувийг эзэлж байна. Тухайлбал:

- "ЗХ-ны 0167 дугаар ангиас шинэ суурьшлын бүс чиглэлийн автозамыг барих ажил"-ын нэмэлт ажил,
- Орон нутгийн чанартай хатуу хучилттай авто замын засвар, арчлалтыг хийх ажлын нэмэлт ажил,
- Номгон сумын 15 ортой эмнэлгийн барилгын нэмэлт ажил,
- Цогт-Овоо сумын 960 хүүхдийн сургуулийн барилгын нэмэлт гэрээ ажил,
- Баян-Овоо сумын төвийн автозамын ажлын нэмэлт ажил,
- Төрийн архивын тасгийг нягтруулсан шүүгээгээр хангах нэмэлт ажил,
- Нутгийн удирдлагын ордны барилгыг засварлах нэмэлт ажил,
- Хүрмэн сумын төвд цэнгэлдэх хүрээлэнгийн барилгыг барьж ашиглалтад оруулах нэмэлт ажил,
- Цогт-Овоо суманд уурын зуух шинэ барилгын нэмэлт ажил,
- Номгон сумын төвийн дулаан цэвэр бохирын шугам шинээр барих ажлын нэмэлт ажил,
- Нойтон аргаар үнс зайлуулах систем нэмэлт ажлууд байна.

1.21 Дээрх нэмэлт ажлууд нь ашиглагч болон захиалагч талуудаас гарсан саналд нэмэлт гэрээ байгуулан хийсэн ажлууд байна. Энэ нь зарим төсөл арга хэмжээний төлөвлөлтөд ашиглагч байгууллагуудаас санал авахгүй, авсан саналыг тусгахгүй байгаатай холбоотой байна.

1.22 Хэдийгээр дээрх нэмэлт ажлууд ТБОНӨХБАҮХАТХ-ын 34.1.4 дэх хэсгийг баримталсан байгаа боловч шинээр хэрэгжиж байгаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5³-д заасантай нийцэхгүй байна. Иймд зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага аймгийн Засаг даргад хүргүүлээ.

А.3 Зарим төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.

1.23 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2023 онд 211 барилга, байгууламжид 265,567.3 сая төгрөг, 120 их засварт 23,793.7 сая төгрөг, хамгийн олон буюу 307 тоног төхөөрөмжид 61,445.2 сая төгрөг, хамгийн бага буюу 105 техник, эдийн засгийн үндэслэлд 10,487.4 сая төгрөгийг тус тус баталсан байна.

1.24 Дээрх ангилалд багтахгүй зардлын шинж чанартай 27 төсөл, арга хэмжээд 2,210.2 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

³ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гарахгүй байх

Хүснэгт 3 Төсөл, арга хэмжээний ангилал

ТЭЗ-ын нэр	Ангилал	2023 оны төлөвлөлт		2023 оны санхүүжилт		
		ТАХ-ний тоо	Хувь	Батлагдсан дүн /Сая төгрөг/	Гүйцэтгэл /Сая төгрөг/	Хувь
Өмнөговь	Барилга, байгууламж	211	27.4	265,567.3	167,092.8	62.9
	Их засвар	120	15.6	23,793.7	16,116.7	67.7
	Тоног төхөөрөмж	307	39.9	61,445.2	45,364.3	73.8
	ТЭЗҮ	105	13.6	10,487.4	4,503.0	42.9
	Бусад	27	3.5	2,210.2	2,139.9	96.8
	Дүн	770	100	363,503.8	235,216.7	64.7

Эх сурвалж: Аудитын судалгаа

1.25 Орон нутгийн 2023 оны төсвөөс хөрөнгө оруулалтаар нийт 770 төсөл, арга хэмжээнд 363,503.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж жилийн эцсийн гүйцэтгэлээр 658 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулан баталгаажсан гүйцэтгэлээр 235,216.7 сая төгрөг олгосон байна.

1.26 Харин аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа “Даланзадгад суманд мэдээллийн технологийн төв, сургалт, дундын оффисын Дата төв байгуулах” ажлын бодит гүйцэтгэл 80 хувьд хүрээгүй байхад санхүүжилтийг олгосон байна.

Зураг 1 Дата төвийн барилга 2024 оны 4 дүгээр сар



1.27 Энэ нь ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.12⁴-т заасантай нийцэхгүй байна. Иймд зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

1.28 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх “Даланзадгад-Баяндалай-Ноён-Сэврэй-Гурвантэс” чиглэлийн хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэн барих 15 км” 23,355.3 сая төгрөгийн ажилд гэрээ байгуулсан хугацаанаас хойш 23 хоногийн дараа санхүүжилтийн 40 хувь болох 9,140.3 сая төгрөгийг баталгаажсан гүйцэтгэлийг үндэслэж олгосон боловч өвлийн улиралд гэрээний үргэлжлэх хугацааны 6.3 хувьд нийт ажлын 40 хувийг хийсэн байх үнэмшилгүй, нотлогдохгүй байна.

1.29 Аймаг, сумд нь төсвийн тодотголоор төсөл, арга хэмжээг нэмж баталснаас худалдан авах ажиллагааны хугацаа оройтсон, огт зарлаагүй, худалдан авах ажиллагаанд гүйцэтгэгч

⁴ Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно

шалгараагүй, захиалагч гэрээгээ цуцалсан зэрэг шалтгаанаар зарим төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

1.30 Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 456 дугаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 2⁵-т заасны дагуу орон нутгийн төсвийн хөрөнгийн гүйцэтгэл хүрээгүй 10,820.0 сая төгрөгийн 49 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

1.31 Энэ нь хэдийгээр Засгийн газрын тогтоолыг үндэслэн байршуулсан боловч төсөл, арга хэмжээ хэрэгжих боломжгүй болсон тохиолдолд барьцаа хөрөнгөний данснаас гаргах, зарцуулахад эрх зүйн хувьд хүндрэл үүсэх эрсдэлтэй байна.

БҮЛЭГ 2. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.


Б.1. Худалдан авах ажиллагааг төлөвлөгөөт хугацааны дагуу хэрэгжүүлэхгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна.

2.1. Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч “2023 оны худалдан авах ажиллагаа”-ны төлөвлөгөөг 2022 оны 12 дугаар сарын 09-ий өдөр баталсан байна. Уг төлөвлөгөөнд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2023 онд хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд нийт 229 төсөл арга хэмжээг 204,104.2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгасан байна.

2.2. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт төсөл, арга хэмжээний 88 хувийг 1 дүгээр улиралд, 10 хувийг 2 дугаар улиралд, үлдсэн 2 хувийг 3 болон 4 дүгээр улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

2.3. Харин худалдан авах ажиллагааны 2023 оны тайлангаас харахад нийт төсөл, арга хэмжээний 27 хувийг 1 дүгээр улиралд, 36 хувийг 2 дугаар улиралд, 19 хувийг 3 дугаар улиралд, үлдсэн 18 хувийг 4 дүгээр улиралд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Дүрслэл 1 ХАА-ны төлөвлөгөө, гүйцэтгэл



Эх сурвалж: Аймгийн ХАА-ы 2023 оны төлөвлөгөө, ХАА-ы тайлан

⁵ Энэ тогтоолын 1.1-1.3-т заасан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэх болон хөрөнгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулах, санхүүжүүлэхэд шалгуур үзүүлэлт гаргаж, нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Сангийн сайдад даалгасугай.

2.4. Худалдан авах ажиллагааг 2023 оны 3, 4 дүгээр улиралд зарласан 14,670.7 сая төгрөгийн 12 төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн хугацаандаа бүрэн хэрэгжих боломжгүй болж он дамжсан байна.

2.5. Дээрх зөрчил нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4⁶ заалттай нийцэхгүй байна. Иймд аудитаар алдаа зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

2.6. Худалдан авах ажиллагааг төлөвлөгөөт хугацаандаа бүрэн зарлаж хэрэгжүүлж амжихгүй байгаа нь зарим төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, ажлын даалгавар зураг төсөв зэргийг тухайн онд боловсруулж байгаагаас шалтгаалж байна.

2.7. Төсвийн ерөнхийлөн захирагч нь уг нөхцөл байдалд анхаарч, үр дүнтэй арга хэмжээ авахгүй бол 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1⁷ заалтын хэрэгжилт хангагдахгүй байх үр дагавар гарч болзошгүй байна.

Б.2 Зарим төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу шалгаруулаагүй байна.

2.8. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжихээр баталсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг аймгийн Засаг дарга Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагааны алба, сумдын Засаг дарга нарт олгосон байна.

2.9. Тендерийг зохион байгуулж гүйцэтгэгчийг шалгаруулахдаа нийт төсөл, арга хэмжээний 40 хувьд нээлттэй тендер шалгаруулалт, 25 хувьд харьцуулалтын арга, 16 хувьд ЗҮГСШЖ, 19 хувьд шууд гэрээ байгуулах аргыг ашигласан байна.

Хүснэгт 4 ТАХ-ы гүйцэтгэл, ХАА-нд мөрдөгдсөн журам

Ангилал	2023 оны гүйцэтгэл		2023 оны санхүүжилт		ХАА-нд мөрдөгдсөн журам			
	ТАХ-ний тоо	Хувь	Гэрээний дүн (сая төгрөг)	Олгосон Гүйцэтгэл (Сая төгрөг)	НТШ	ХА	ЗҮГСЖ	ШГ
Барилга байгууламж	166	25.2	230,532.7	167,092.8	127	26	-	12
Их засвар	99	15.1	20,039.9	16,116.7	46	28	-	22
Тоног төхөөрөмж	283	43.0	49,175.5	45,364.3	85	108	-	79
ТЭЗҮ	87	13.2	7,335.0	4,503.0	-	-	101	-
Бусад	23	3.5	2,284.6	2,139.9	4	4	-	16
Дүн	658	100	309,367.7	235,216.7	262	166	101	129

Эх сурвалж: Аудитын судалгаа


2.10 Худалдан авах ажиллагаанд тайлант онд сангийн яаманд тендерт оролцогчдоос 29 гомдол гарсан бөгөөд 22 тендер шалгаруулалтад нь захиалагчийн шийдвэрийг үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн байна.

⁶ Төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх

⁷ батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;

2.11 Аймгийн ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн 13/11 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийх ерөнхий нэрээр 235 төсөл, арга хэмжээг баталсан бөгөөд төсөл, арга хэмжээг 456 болгон жижиглэн задалж хэрэгжүүлсэн байна.

Дүрслэл 2 ТАХ-ы гүйцэтгэл өмнөх онтой харьцуулсан байдал



Эх сурвалж: Аудитын судалгаа

2.12 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.⁸ -д батлагдсан төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг олон хувааж зарлахыг хориглосон байдаг.

2.13 Харин орон нутгийн төсвийн хөрөнгөөр “Өмнөговьд үйлдвэрлэл” борлуулалтын төвд хийх хөрөнгө оруулалтыг задалж харьцуулалтын аргаар 2, шууд гэрээ байгуулахаар 4 ажил болгон хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 5 ТАХ-ыг задалсан байдал /Жишээ нь/

№	Ерөнхий нэр	Баталсан дүн /Сая төгрөг/	Задарсан нэр	Санхүүжих дүн /Сая төгрөг/
1	Орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүн, нутагшсан сортыг хэрэглэгчдэд таниулах, холбох зорилгоор “Өмнөговьд үйлдвэрлэл” борлуулалтын төвийн тохижуулах	200.0	Өмнөговьд үйлдвэрлэл борлуулалтын цэгийг тохижуулах хүрээнд барилгын засал хийх ажил	75.9
2			Өмнөговь үйлдвэрлэл борлуулалтын төвийг тохижуулах хүрээнд тоног төхөөрөмж нийлүүлэх	19.7
3			Өмнөговьд үйлдвэрлэл борлуулалтын цэгийг тохижуулах хүрээнд барилгын засал хийх ажил	42.9
4			Өмнөговь үйлдвэрлэл борлуулалтын төвийн тохижилт	16.9
5			Өмнөговь үйлдвэрлэл борлуулалтын төвийн тохижилт	19.3
6			Өмнөговь үйлдвэрлэл борлуулалтын төвийг тохижуулах хүрээнд шилэн тавиур нийлүүлэх	18.7

Эх сурвалж: Аудитын судалгаа

2.14 Төсөл, арга хэмжээг олон хувааж шууд гэрээ байгуулж хэрэгжүүлэх нь худалдан авах ажиллагаа нь хуульд нийцээгүйгээс гадна төсвийн үр ашиг хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна.

2.15 Аудитаар аймгийн орон нутгийн өмчийн газраас зарласан зарим төсөл арга хэмжээнд дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- "Даланзадгад-Баяндалай-Ноён-Сэврэй-Гурвантэс" чиглэлийн хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлэн барих 23,667.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын

⁸ Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно

гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тендерийн өгөгдлийн шалгуур үзүүлэлтэд тусгасан түншлэлийг төлөөлөгч эрх бүхий гишүүний борлуулалтын орлого 40 ба түүнээс дээш хувьд хүрээгүй оролцогчийг шалгаруулсан,

- Даланзадгад суманд худалдааны төв захын барилга барих 1,181.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа мөн борлуулалтын орлогын шаардлага хангаагүй оролцогчийг шалгаруулсан,
- Даланзадгад суманд мэдээллийн технологийн төв, сургалт, дундын оффисын "DATA" төв байгуулах" 1,991.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын тендер шалгаруулалтын бичиг баримтыг хуульд нийцүүлэн боловсруулаагүйгээс тендерийн шаардлага хангаагүй оролцогчийг шалгаруулсан байна.

2.16 Дээрх зөрчлийг хуулийн байгууллагаар шалгуулах хүсэлтийг УАГ-т хүргүүлсэн.

2.17 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4⁹-д цахим дэлгүүрээс худалдан авалт хийх тухай заасан. Гэвч цахим дэлгүүрт байршсан зарим бараа, тоног төхөөрөмж нь зах зээлийн үнээс өндөр байдаг нь 3 суманд хөрөнгө оруулалтаар компьютер, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг тендер шалгаруулалтаар хэрэгжүүлэх шалтгаан болсон байна.

2.18 Сумын ЗДТГ-ын батлагдсан орон тоонд худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн байдаггүй нь зарим сумын худалдан авах ажиллагаанд зөрчил гарахад нөлөөлж байна.

БҮЛЭГ 3. ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛД ИЛЭРСЭН ЗӨРЧЛҮҮД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ДҮНГ БУУРУУЛЖ БАЙНА.

В.1 Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд илэрсэн зөрчил хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна.

3.1 Аудитын явцад зарим төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй танилцахад дараах асуудал илэрлээ. Үүнд:

- Аймгийн төсвийн хөрөнгийн 1,160.5 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн "Төв цэцэрлэгт хүрээлэнгийн засвар, тохижилтын ажлыг эхлүүлэх" ажлыг холбогдох шийдвэргүйгээр батлагдсан зургийг өөрчилж гүйцэтгэсэн. Мөн батлагдсан зураг өөрчилсөн ч төсөвт өөрчлөлт оруулаагүй байна.


Зураг 2 Төв цэцэрлэгт хүрээлэн



- Улаанбаатар хотод баригдаж байгаа 2019 онд эхлүүлсэн "Оюутны хотхон"-ны бүтээн байгуулалт 5 жилийн хугацаа өнгөрсөн ч дуусаагүй байна.

⁹ Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно

Зураг 3 Оюутны хотхон



- Аймгийн төсвийн хөрөнгийн 1,614.1 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн Даланзадгад сумын 3-р багийн төв орчмын зогсоол автозамын ажлын зураг төсөвт туссан Цогжавхлан дэлгүүрийн баруун талын хэсгийн авто зам, зогсоол, явган хүний замын хэсэг хийгээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгож хүлээн авсан байна.

Зураг 4 Явган хүний замын зураг



- “Даланзадгад сумын 3 дугаар сургуульд хүүхдийн хоолны газрын барилга барих” ажилд барилгын гүйцэтгэгч талын хариуцлагагүй байдлаас шалтгаалан үндсэн хийц бүтээц болох цутгамал хананд цав гарсан байна.

Зураг 5 Хананд цууралт өгсөн байдал





- “Орон нутгийн чанартай авто замын засвар арчлалт” ажлын зарим хэсэгт захиалагч, гүйцэтгэгч талуудын хариуцлагагүй байдлаас шалтгаалан авто замын хийц бүтээц эвдрэл ихтэй хийгдсэн байтал яаралтай засах арга хэмжээ авахгүй байгаагаас авто замаар зорчигч иргэдийн эд хөрөнгө, эрүүл мэнд, амь нас хохирох эрсдэлийг бий болгосон байна.

Зураг 6 Замын хэсэг



- Даланзадгад сумын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн “3 дугаар сургуулийн спорт заалны засвар хийх” ажлын модон шал зарим хэсэгт зай завсар гарсан байна.

Зураг 7 Шалны хэсэг



- “Төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах” ажилд нийлүүлэгдсэн 260 ширхэг сандал ажлын даалгаварт заасан “сайжруулсан арьсан болон даавуун эдэлгээ даах материалтай байх” гэснээс зөрүүтэй байна.

Зураг 8 Нийлүүлэгдсэн сандал



- Ханбогд сумын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн 19.9 сая төгрөгийн “Үлэмжийн чанар соёлын төвд 60 ширхэг ботгоны баг худалдах авах” ажлын 30 ширхэг ботгоны баг дутуу нийлүүлэгдсэн байна.
- “Үлэмжийн чанар соёлын төвд цамын иж бүрэн хувцас авах” ажлын цамын хувцас нь ажлын даалгавартай нийцэхгүй эдэлгээнд орсон хуучин байна.

Зураг 9 Нийлүүлэгдсэн хувцас



3.2 Дээрх илэрсэн зөрчлүүдэд дахин давтахгүй байх, арилгах албан шаардлага хүргүүлээ.

В.2 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

3.3 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад Төрийн аудитын байгууллагаас жил бүр аудит хийж байгаа ч алдаа зөрчил давтагдан гарсаар байна. Энэ нь төсөл, арга хэмжээнд тавих хяналт муу байгаатай холбоотой байна.

3.4 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээг ГХБХБГ болон “Өмнөговь корпорац” ОНӨААТҮГ, сумдын ЗДТГ-ын томилогдсон албан тушаалтнууд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

3.5 Сумдын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээнд мэргэжлийн бус сумын ЗДТГ-ын даргын томилсон албан тушаалтнууд хяналт хэрэгжүүлж байгаа нь хяналт хангалтгүй хэрэгжүүлэх үндсэн шалтгаан болж байна.

3.6 ГХБХБГ, “Өмнөговь корпорац” ОНӨААТҮГ-уудын тусгай мэргэжлийн орон тооны хүртээмжээс шалтгаалан зарим төсөл, арга хэмжээнд тавих хяналтыг хангалтгүй хийсэн байна.

3.7 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийх ажлын тоо, санхүүжилт жил бүр өсөж байгаа тул захиалагчийн хяналтыг сайжруулж мэргэжилтнүүдийн чадвар, хүний нөөцөд анхаарах шаардлагатай байна.

3.8 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2023 онд төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч зарим байгууллагуудад эрх шилжүүлэн олгосон хөрөнгө оруулалтын ажлуудад аймгийн Засаг даргын захирамжид хяналт хийхийг даалгасан Цэргийн штаб, Хууль эрх зүйн хэлтэс хяналт хэрэгжүүлээгүй байна.

3.9 Хяналт хэрэгжүүлээгүйгээс шалтгаалан Төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагуудад эрх шилжүүлэн олгосон хөрөнгө оруулалт үр дүнгүй, алдаа зөрчил гарсан байна. Үүнд:

- “Хилийн 0166 дугаар ангийн Овоотын бага сургуулийн барилгыг засварлах” ажлын тендерийн хэмнэлт болох 12.6 сая төгрөгийг зарцуулсан. Мөн тус сургуулийн барилгыг одоог хүртэл ашиглахгүй, ашиглах эсэх нь тодорхой бус байна.

Зураг 10 Барилгын 2024 оны 2 дугаар сарын байдал



- “Хилийн 0166 дугаар ангийн соёлын төвийн техник хэрэгслийг шинэчлэх, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх” 29.9 сая төгрөгийн ажилд тендер шалгаруулалт зохион байгуулаагүй байна.
- “Өмнөговь аймаг дахь Шүүхийн тамгын газрын ариун цэврийн өрөөний засварын ажилд дэмжлэг үзүүлэх” ажлын тендерийн хэмнэлт болох 0.2 сая төгрөгийг зарцуулсан байна.
- “Зэвсэгт хүчний 0167 дугаар ангийн эргэлтийн байрыг засварлах” 48.7 сая төгрөгийн ажилд тендер шалгаруулалт зохион байгуулаагүй байна.

3.10 Дээрх зөрчлүүдэд дахин давтахгүй байх, зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлээ.

В.3 Шинээр бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байх зөрчил буурсан байна.

3.11 Аймгийн хөрөнгө тайлант онд орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС, говийн оюу хөгжлийг дэмжих сан, бусад эх үүсвэрүүдээс нийт 174,335.4 сая төгрөгийн 384 хөрөнгөөр өссөн байна.

3.12 Орон нутгийн өмчийн газар болон сумдын санхүү албаны дарга нар нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтөд тавих хяналт сайжирсантай холбоотойгоор шинээр бий болсон хөрөнгүүдийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй зөрчил буурсан байна.

3.13 Зарим дууссан орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгүүдийг ашиглагч байгууллага нягтлан бодох бүртгэлд тусгаагүй зөрчил илэрсэн. Үүнд:

- Сэврэй сумын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 12.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй,
- Цогтцэций сумын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 92.7 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй,
- Ханбогд сумын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 54.8 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг бүртгэлт тусгахдаа НӨАТ ороогүй дүнгээр 49.8 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.

3.14 Дээрх зөрчлүүд нь нягтлан бодогчдын хариуцлагагүй байдал, бүртгэлд тусгахыг үүрэг болгосон захирамж, шийдвэр нь тухайн байгууллагуудад хугацаандаа очихгүй байгаа зэргээс шалтгаалсан байна. Иймд зөрчлийг аудитын явцад арилгах боломжтой зөрчлийг арилгуулж, боломжгүй зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

3.15 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн зардлын шинж чанартай, үндсэн хөрөнгөд бүртгэх боломжгүй 3,913.0 сая төгрөгийн 52 төсөл, арга хэмжээ байгаа нь төсвийн төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөнтэй холбоотой байна.

БҮЛЭГ 4. ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ БАЙГАА НЬ ҮР ДҮНГ БУУРУУЛЖ БАЙНА

Г.1 Зарим төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу ашиглахгүй байна.

4.1 Аудитын явцад зарим төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхтэй танилцахад дараах асуудлууд илэрсэн. Тухайлбал:

4.2 “Хөгжимт жүжгийн театрын шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах” ажлын 287.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөс 38.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг шийдвэргүйгээр ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс ашиглаж, бүртгэсэн байна.

4.3 Төсвийг зориулалт бусаар ашигласан зөрчилд давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүллээ.

4.4 “Ажнай талбайн баруун талын авто зогсоолын ажил”-аар бий болсон авто зогсоолыг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хувийн хэвшлийн байгууллага үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Зураг 11 Хувийн хэвшил ашиглаж байгаа байдал



4.5 Дээрх нийтийн зориулалтай талбайд хувийн хэвшил үйл ажиллагаандаа ашиглаж байгаа нь төсвийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна. Иймд дээрх зөрчилд аймгийн Засаг даргад арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өглөө.

4.6 “Гурвантэс сумын 28, 3 дугаар цэцэрлэгийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах” ажилд нийлүүлсэн 2 ширхэг ухаалаг дэлгэц зориулалт, хүчин чадлаар нь ашиглахгүй байна.

Зураг 12 Ашиглаж байгаа байдал



4.7 Дээрх ухаалаг дэлгэцийг үндсэн зориулалтаар нь ашиглахгүй зөвхөн дэлгэц томруулах хэмжээнд ашиглаж байгаа нь хөрөнгө оруулалтыг хэрэгцээ шаардлагыг бодитой тооцоогүй байгаатай холбоотой байна. Иймд тухайн зөрчлийг давтан гарахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Г.2 Зарим төсөл, арга хэмжээ нь хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шаардлага хангаагүй байгаа нь үр дүнг бууруулж байна.

4.8 Аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалт дунд болон урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдуулж, эдийн засгийн ач холбогдлоор эрэмбэлсэн нь нотлогдохгүй. Мөн хөрөнгө оруулалтыг хэт жижиглэж төсвийн байгууллагуудын урсгал зардлын шинжтэй хөрөнгө оруулалт төлөвлөж хэрэгжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна. (Дэлгэрэнгүйг нэгдсэн судалгаанаас)Тухайлбал:

- Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2.0-20.0 сая төгрөгийн өртөгтэй нийт 69 төсөл, арга хэмжээнд 1,113.6 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Ханбогд сумын хөрөнгө оруулалтаар “Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, өвс тэжээл худалдан авах” ажилд 1,000.0 сая төгрөг зарцуулсан,
- Даланзадгад сумын хөрөнгө оруулалтаар “Зорилтод бүлгийн иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах” ажилд 107.3 сая төгрөг, “Өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын хүрээнд өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх” ажилд 66.0 сая төгрөг, “Дунд үеийн орон сууцуудын дээврийг засварлах /20, 21, 23, 28-р байр/” ажилд 483.0 сая төгрөг зарцуулсан,
- Баян-Овоо сумын хөрөнгө оруулалтаар “100 жилийн бэлтгэл ажил асар майхан авах” ажилд 22.9 сая төгрөг зарцуулсан,
- Манлай сумын төсвийн хөрөнгө оруулалтаар “Нөлөөллийн бус бүсийн айлуудад өвс тэжээлийн тусламж үзүүлэх 2023-2024” ажилд 40.0 сая төгрөг зарцуулсан,
- Сэврэй сумын хөрөнгө оруулалтаар “Архивд техник боловсруулалтын ажил”-д 7.0 сая төгрөг зарцуулсан,
- Гурвантэс сумын хөрөнгө оруулалтаар “Хүчирхийллийг тэвчдэггүй хүн бай” ажилд 7.9 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

4.9 Дээрх зөрчлүүд нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 Улсын болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад тусгахыг хориглосон заалтын 13.3.2¹⁰-т заасантай нийцэхгүй байна. Иймд зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлээ.

¹⁰ Хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалтай бус ашиг олох зорилготой төсөл арга хэмжээ.

4.10 Хилийн 0166 дугаар ангийн Овоотын бага сургуулийн барилгыг засварлах 277.8 сая төгрөгийн ажил хүүхдүүдийн боловсролд чиглэсэн хөрөнгө оруулалт болсон хэдий ч одоог хүртэл багш, салбарын сайдын зөвшөөрөл зэргээс шалтгаалан ашиглахгүй байна. Мөн 2022 оны хөрөнгө оруулалтаар тус ангид хийсэн цэцэрлэг улсын комисс хүлээн аваагүй гэсэн шалтгаанаар ашиглалтгүй байна.

4.11 Цаашид аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх төсөл арга хэмжээг дунд болон урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдуулж, эдийн засгийн ач холбогдлоор эрэмбэлж, хөрөнгө оруулалтын шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4.12 Ханбогд сум төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд “Дулааны цахилгаан станц барих” ажилд 28,984.8 сая төгрөгийн ажил төлөвлөн хэрэгжүүлж байна. Энэ нь сумдаас хамгийн анхны дулааны станцтай болох томоохон бүтээн байгуулалт бий болж байгаа нь хөрөнгө оруулалтын үндсэн зорилготой нийцсэн сайн төсөл, арга хэмжээ болохоор байна.

Зураг 12 Батлагдсан ажлын зураг



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2023 онд 770 төсөл, арга хэмжээнд 363,503.8 сая төгрөг баталсан байна
- Төсөвт төсөл, арга хэмжээний 27 хувийг 1 дүгээр улиралд, 36 хувийг 2 дугаар улиралд, 19 хувийг 3 дугаар улиралд, үлдсэн 18 хувийг 4 дүгээр улиралд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна
- Сумын ЗДТГ-ын батлагдсан орон тоонд худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн байхгүй нь сумдын худалдан авах ажиллагаанд зөрчил гарахад нөлөөлсөн байна
- Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд алдаа зөрчил гарч байгаа нь хөрөнгө оруулалтыг үр дүнг бууруулж байна.
- Төсөл, арга хэмжээнд тавих хяналт хангалтгүй байна.
- Аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх төсөл арга хэмжээг дунд болон урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдуулж, эдийн засгийн ач холбогдлоор эрэмбэлж, хөрөнгө оруулалтын шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Р.Сэддорж танаа:

- “Ажнай талбайн баруун талын авто зогсоолын ажил”-аар бий болсон авто зогсоолыг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хувийн хэвшлийн байгууллага үйл ажиллагаандаа ашиглаж байгаад арга хэмжээ авч ажиллах.

Сумдын Засаг дарга нарт:

- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д заасан мэдээллийг бүрэн тусгах.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 1108

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар болон Өмнөговь аймгийн Засаг даргад тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Г.Шижирболд)-т үүрэг болгосугай.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Г.Шижирболд)-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

016010007

